



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймаг дахь Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 3,674,450.00 (гурван сая зургаан зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун тавь) төгрөгийн балансын үнэ, 2,797,758.00 (хоёр сая долоон зуун ерэн долоон мянга долоон зуун тавин найм) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Булган аймаг дахь Прокурорын газрын дарга Д.Доной нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах, сэлбэн ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталсан барилгын доорх газрыг Прокурорын байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж, нөхөн сэргээх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001647

16-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 13 нөхний өдрийн
523 дугаар тогтоолын хавсралт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, төрөл	Хөрөнгийн байршил	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг, м2)	Нэг бүрийн балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Автомашины граж (аж ахуйн аргаар барьсан)	Булган сум 5-р баг өөрийн эзэмшлийн газар	2010.01.28	1	2,355,290.00	1,478,598.00	876,692.00
2	Байгууллагын хашаа (модон хайс)	Булган сум 5-р баг өөрийн эзэмшлийн газар	2012.12.28	12	1,319,160.00	1,319,160.00	0.00
Нийт дүн			2		3,674,450.00	2,797,758.00	876,692.00
					(гурван сая зургаан зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун тавь)	(хоёр сая долоон зуун ерэн долоон мянга долоон зуун тавин найм)	(найман зуун далан зургаан мянга зургаан зуунерэн хоёр)